

“БҮТЭЭЛЧ-ҮЙЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

2015.04.22

Налайх

1.2014 оны ажлын тайлан цаашдын зорилт, орон тоо цалингийн талаар.

Сонсогч нь:

Хугацаа: 10 минут

2.2014 оны үйлдвэрийн үйл ажиллагаа, жилийн эцсийн санхүүгийн тайланд өгөх дүгнэлт

Сонсогч нь:

Хугацаа: 10 минут

3.ТУЗ-ийн бүрэлдэхүүнд оруулах зарим өөрчлөлтийн талаар хэлэлцэх.

Хугацаа харгалзахгүй

4.Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой санал шүүмжлэл

Хугацаа харгалзахгүй

5.Хурлыг 2015 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 11.00 цагаас эхлэн 14.00 цагт дуусгана.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

“БҮТЭЭЛЧ-ҮЙЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

2015.04.22

Налайх

1.2014 онд тус компанийн хийж гүйцэтгэсэн ажил, цаашид хийх ажил, үйлдвэрийн засвар шинэчлэл, орон тоо, цалингийн хэлбэр хэмжээг тогтоох талаар.

Сонсгогч нь: Д.Эрдэнэбилэг

2.2014 оны үйлдвэрийн үйл ажиллагаа, жилийн эцсийн санхүүгийн тайланд өгөх дүгнэлт.

Сонсгогч нь Д.Эрдэнэбилэг

3.ТУЗ-ийн бүрэлдэхүүнд зарим өөрчлөлт оруулах тухай.

**“БҮТЭЭЛЧ-ҮЙЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРАЛД КОМПАНИЙ ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН ЗАРИМ ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ САНАЛ**

2015.04.22

Налайх дүүрэг

**М.Нэргүй:** -ТУЗ-ийн дарга

Компаний тухай хуулийн дагуу тус компаний ТУЗ нь 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж ирсэн ба 2015 он гарсаар ТУЗ-ийн гишүүн М.Баярсайхан, Ц.Пүрэвсүрэн, Г.Тамир нар ТУЗ-ийн бүрэлдэхүүнээс гарсан тул ТУЗ-ийн гишүүдийг нөхөн сонгох шаардлага гарсан. ТУЗ-ийн даргын хувьд миний бие хуучин ТУЗ-ийн гишүүн Мядагийн Нэргүй, Ганбаатарын Сарантуяа, Лувсанбалдангийн Даваахүү, Нэргүйн Энхболд, Очирын Оюунцэцэг /хараат бус гишүүн/ нарыг үлдээх санал оруулж бусад гишүүдийн нэрийг дэвшүүлэх эрхийг гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбилэгт үлдээж байна.

**Д.Эрдэнэбилэг:** -Гүйцэтгэх захирал

Миний хувьд доорхи хүмүүсийн нэрсийг оруулж байна. Үүнд: Дамдиндоржийн Баярсайхан, Дамдиндоржийн Эрдэнэбилэг, Пүрэвжавын Оюунхүү, хараат бус гишүүнээр Дамдиндоржийн Эрдэнэтулга нарыг оруулж байна.

Энэ саналыг хэлэлцснээр “Бүтээлч-Үйлс” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдээр:

- 1.М.Нэргүй
- 2.Д.Эрдэнэбилэг
- 3.Н.Энхболд
- 4.О.Оюунцэцэг
- 5.Л.Даваахүү
- 6.Г.Сарантуяа
- 7.П.Оюунхүү
- 8.Д.Баярсайхан
- 9.Д.Эрдэнэтулга

нарыг сонгохыг оролцогчид 100% дэмжив.

“БҮТЭЭЛЧ-ҮЙЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2015.04.22

Налайх

1.Хурал 2015 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 11.00 цагт “Бүтээлч-Үйлс” ХК-ийн байранд эхлэн ТУЗ-ийн дарга М.Нэргүй хувьцаа эзэмшигчдийн ирцийг танилцуулав. Үүнд:

- 1.М.Нэргүй 20%
- 2.Сарантуяа 12%
- 3.Н.Энхболд 20%

Мөн Б.Нагнай, О.Оюунцэцэг, Л.Даваахүү, М.Цэцэгдэлгэр, Ж.Цэрэннадмид, Ц.Цэрэнпагма нарын хувьцаа эзэмшигчид оролцов.

Хурлын ирц 60,9%-тай байгаа тул хурлыг нээх санал оруулахад 100%-ын саналаар хурал эхлэв.

2.Хувьцаат компаний дүрэм ёсоор хурлын тэргүүлэгчдийг 5 хүний бүрэлдэхүүнтэй сонгох санал оруулж 100%-ийн саналаар дэмжив.

3.М.Нэргүй санал гаргаж

- 1.М.Нэргүй
- 2.Д.Эрдэнэбилэг
- 3.О.Оюунцэцэг
- 4.Ц.Цэрэнпагма
- 5.Л.Даваахүү

нарыг сонгох санал оруулж гишүүдийн 100%-ийн саналаар батлав.

4.Хурлын тэргүүлэгчид байраа эзлэн хуралд хэлэлцэх асуудал, дотоод журмыг танилцуулав.

а).Хурлын нарийн бичгийн даргаар нягтлан бодогч Ж.Цэрэннадмидыг санал нэгтэй сонгон хурлын протоколыг үнэн зөв, бүрэн хөтлөхийг даалгав.

б).Хуралд хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулж, санал авахад өөр санал гараагүй тул 100%-ийн саналаар батлав.

в). Хурлын дэг ёсоор компаний гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбилэг “2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, жилийн эцсийн санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2014 онд хийсэн ажил цаашид тавих зорилтын талаар” сонсгол хийв.

Сонсголыг хавсаргав.

г).”Бүтээлч-Үйлс” ХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд зарим өөрчлөлт оруулах талаар ТУЗ-ийн дарга М.Нэргүй, гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбилэг нар өөрсдийн саналыг хэлж хуралд оролцогчид бүрэн дэмжиж ТУЗ-ийн гишүүдийг батлах тухай хурлын тогтоол гаргах нь зүйтэй гэж үзэв. Дээрх хүмүүсийн гаргасан санал ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнийг хэлэлцсэн тухай протоколыг хавсаргав.

д).Хуралд тавьсан сонсгол ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүний талаар хувьцаа эзэмшигчид өөрсдийн санал хүсэлтээ 10 минутад багтаан хэлэлцэх саналыг хурлын тэргүүлэгчид тавьж хуралд оролцогчид 100% зөвшөөрсөн тул доорхи хүмүүс үг хэлэв.

М.Цэцэгдэлгэр: -Нөхцөл байдалтай танилцлаа.Бидний өмнө хүндрэлтэй асуудлууд тулгарч байсан. Одоо ч гэсэн бүх юм сайн сайхан болчихоогүй байна. Бид бэрхшээлийг даван туулсаар ирсэн. Одоо бүр ч итгэл найдвар өндөр байгаа. Үйлдвэрийн барилгад их засвар хийж өнгө төрх нь сайхан болж байгаад сэтгэл ханамжтай байна. Захиалагч нарын захиалгыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх зорилго бидний өмнө тулгарч байна. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг миний хувьд хүлээн зөвшөөрч байна. Шинэ удирдлагадаа итгэл үзүүлж үр бүтээл, идэвх зүтгэлтэй ажиллана гэдэгт нийт оёдолчдынхоо өмнөөс амлаж байна.

Б.Нагнай: -Шинэ ажлын байр, шинэ удирдлага, шинэ арга барилаар ажиллаж байгаа явдалд ахмад ажилчныхаа хувьд сэтгэл хангалуун байна.Тавигдаж байгаа зорилтоо бүрэн биелүүлэхийн тулд залуу сайхан удирдлага, ТУЗ-ийн гишүүдийнхээ сайн ар тал болж ажлын туршлагаараа дэмжиж ажиллая. Ажилдаа идэвх зүтгэлтэй байж тухайн ажлыг цаг тухайд нь чанартай шуурхай гүйцэтгэе. Бид энэ компанид

ажилласны төлөө ар гэр, амьжиргаагаа залгуулж яваа шүү дээ. Удирдлагууд маань шинэ арга барил, шинэ соргог санаачилга гарган ажиллана гэдэгт итгэл дүүрэн байна.

О.Оюунцэцэг: -Санхүүгийн тайлан, хийгдсэн ажил, цаашид тавих зорилтын талаар сонслоо. Сэтгэл ханамжтай байна. Мөн ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнийг дэмжиж байна. Хурлын тогтоолоор баталгаажуулна биз дээ. Идэвхтэй үр бүтээлтэй ажиллах хэрэгтэй. Үйлдвэрээ үр ашигтай ажиллуулбал бидэнд л хэрэгтэй шүү дээ. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд хараат бус гишүүнээр оруулсан явдалд баярлалаа чармайн ажиллах болно.

Л.Даваахүү: -Та бүхний хэлсэн ярьсныг сонслоо. Цаашид тавих зорилт, шинээр сонгох ТУЗ-ийн гишүүдийн хувьд санал нэгтэй байна.

Д.Эрдэнэбилэг: -Би та нараас бидний ажлыг аль болохоор дэмжиж ажиллахыг хүсч байна. ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнд сэтгэл ханамжтай байна. Ихэнх нь тус үйлдвэрт он удаан жил ажилласан, арвин баялаг туршлагатай хүмүүс байна. Бид аль болох олон аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж, ажлын захиалгаар таслахгүй байхын төлөө ажиллах болно. Компаний удирдах нөхөд, ТУЗ-ийн гишүүд маань идэвхтэй ажиллаарай гэж дахин хүсэх байна. Компаний удирдлага болон ТУЗ нь нээлттэй, ил тод идэвхтэй ажиллаарай гэдэг санал оруулж хурлын протоколд тусгая. Компанийн удирдлага, ТУЗ нь нягт хамтран ажиллаж аливаа асуудлыг нухацтай ярилцаж шийдвэрлэнэ гэдэгт бүрэн итгэж байна. Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Үг хэлэх, санал гаргах хүн байхгүй тул санал хүсэлтийг тасалбар болгов.

Хурлын тэргүүлэгч О.Оюунцэцэг хувьцаа эзэмшигчдийн хурлын нэг, хоёрдугаар тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлыг тогтоолыг хуралд оролцогчид 100% дэмжиж батлав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг бүрэн бүрдүүлэхийг гүйцэтгэх захирлаар Д.Эрдэнэбилэгт протоколоор даалгая.

Хурлыг хааж ТУЗ-ийн дарга М.Нэргүй товч үг хэлж бүгдэд нь ажлын амжилт хүсэв.

Хурал 2015 оны 04 сарын 22-ны өдрийн 13 цаг 30 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙСЭН



Ж.ЦЭРЭННАДМИД